

ЕВРОПЫН СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭГЧДИЙН СОЁЛЫН ТУХАЙ ҮЗЭЛ (Онол ба түүхийн аспект)

Т.Дорждагва - МУИС, НШУС, Философийн тэнхим, доктор, профессор

Түлхүүр үг: Соён гэгээрүүлэлтийн эрин үе, соёлын онол ба түүх, соёлын философи, Жан-Жак Руссо, Маркиз Виктор Рикети де Мирабо, Йоганн Готфрид Гердер

Соён гэгээрүүлэлтийн эрин үе нь Европын түүхэнд онцгой хуудас болж орсон юм. Урд өмнө хэзээ ч шашин болон нийгмийн дарангуйллаас түргэн ангижрах найдвар төрж хүний оюун ухааны нэр хүнд өндөр дуугаар тунхалагдаж, сүм хийдийг улангасан шүүмжлэх шүүмжлэл сонсогдоогүй байв. Д'Алембер ХҮШ зууныг "философичдын зуун" гэж нэрлэсэн. Учир нь урд өмнө нь хэзээ ч тийм гялалзсан ухаантнууд нэгэн зэрэг олноороо гарч ирээгүй ба бас хэзээ ч нийгмийн эдийн засаг, улс төр, оюун санааны хүрээнд гарсан үйл явцад нийгмийн сэтгэлгээ тийм хүчтэй нөлөөлөл үзүүлж байгаагүй юм.

Ф.Энгельс "Дюрингийн эсрэг"-ийнхээ өмнөх үгэнд соён гэгээрлийн үеийг тодорхойлохдоо: "Ойртож байгаа хувьсгалд зориулан Франц дахь тэргүүний хүмүүсийг толгойг гэгээрүүлж байсан агуу их хүмүүс өөрсдөө туйлын хувьсгалч байв. Ямар гаралтай байлаа гэсэн гадаад нэр төрийг тэд зөвшөөрдөггүй байжээ. Шашин шүтлэг байгалийг ойлгох ойлголт, нийгэм, төрийн байгуулалт энэ бүхэн нь хамгийн хайр найргүй шүүмжлэгдэж, энэ бүгд оюун ухааны шүүхийн өмнө очих ёстой болж, нэг бол өөрийг оршин байгаа байдлыг зөвтгөх, эсхүл оршин байгаа болих ёстой болж байна. Бүх оршин байгаа юмны цорын ганцхан хэмжүүр бол сэтгэн бодох ухаан болсон юм" /1. 17-18/ гэжээ.

Хэн бүхний сайн мэдэх Вольтер ба Руссо, Монтескье ба Ламетри, Гассенди ба Дидро, Мабли ба Морелли, Гольбах ба Мирабо, Вашингтон ба Тюрго, Джефферсон ба Кондорсе, Пейн ба Франклин, Гердер ба Гёте, Фергюссон ба Д'Алембер зэрэг агуу хүмүүсийг соён гэгээрлийн үе төрүүлжээ.

Тэдгээрийн зарим нь соёл ба байгалийн харьцааны тухай, иргэншлийн хөгжлийн зөрчлийн тухай, янз бүрийн соёлын ертөнцийн харилцан үйлчлэх онцлогийн тухай асуудлуудыг илүү түлхүү авч үзсэн нь тодорхой байдаг. Энд юуны түрүүнд Руссо, Мирабо, Гердер нарыг нэрлэж болох бөгөөд тэднийг соёл судлалын онолын үндэслэгчдийн тоонд зүй ёсоор оруулж болно. Учир нь, XIX зууны төдийгүй, XX зууны сэтгэгчид өөрсдийн онолын байгууламжийг тэдний үзэл санааны цогцолбор дээ тулгуурлан барьжээ.

1. Жан-Жак Руссо

Жан-Жак Руссо /1712-1778/ Францын соён гэгээрүүлэлтийн томоохон төлөөлөгч гэж түүхэнд тэмдэглэгдэж, түүнийг 1793 оны Конвентийн зүтгэлтнүүдийн оюун санааны эцэг, хүмүүжлийн гэгээрүүлэх онолыг бүтээсэн авъяаслаг сурган хүмүүжүүлэгч, ёс суртахуунч, томоохон зохиолч, эрх зүйч, францын хөрөнгөтний хувьсгалын гол үзэл сурталчийн нэг гэж тооцон үздэг. Тэрээр хүмүүсийн жам ёсны тэгш эрхийн тухай зарчмыг үндэслэн "Нийгмийн хэлэлцээр"-ийн үндэс, үзэл баримтлалыг бүтээж, Гоббс, Локк нартай хамт дэлхийн олонх оронд дараачийн хоёр зууны туршид ялсан хөрөнгөтний ардчилсан

нолын үндсийг тавьжээ. Хүн төрөлхтний түүхэн дэх анхны үндсэн хууль болох АНУ-ын үндсэн хуулийн үндсийг тавьсан “Эрхийн тухай Билль” ч, Оросын ирээдүйн Бүгд Найрамдах Улсын үндсэн хууль гэж декабристууд үзсэн Пестелийн “Русская Правда” ч Руссогийн бүтээлсэн хүн төрөлхтний түүхэн дэх анхны конституци болох “Хүн ба иргэний эрхийн тунхаглал”-гүйгээр буй болон гарч чадахгүй байсан нь эргэлзээгүй юм.

Руссо Женевийн нэгэн цагчны гэр бүлд төржээ. Хожим тэрээр өөрийн нийтлэлээс болоод Францаас хөөгдөхөд Швейцарын иргэн болох боломжийг түүнд олгосон байдаг. Түүний хүүхэд ахуй хийгээд залуу үед холбогдох баримт нэн хомсхон. Тэр үеийнх нь тухай бүдэг бадаг төсөөллийг зөвхөн хожим бичсэн “Таминчлал”-аас нь олж болно. Хэрэв намтарчилсан энэ эх сурвалжинд тулгуурлан авч үзвэл Руссогийн хүүхэд ахуй хийгээд залуу нас цэлмэг байгаагүй бололтой. Тэрээр хэрэгцээний зүйлийг эрт ухаарч, боловсролтой хүн болохын тулд чармайлт гаргажээ. Орон гэрээ эрт орхиж, амьдрах газар, орхлэх үйлээ сольж, олон жилийг тэнэмэл амьдралаар өнгөрүүлжээ. Тэрээр зарц, савтаслагч, хөгжимчин ч байж үзэж. ХҮИИ зууны үл гүйцэлдэх коммунизмын нэртэй төлөөлөгчдийн нэг, европын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхэнд орсон Г.Маблийн тэр бүлд нэгэн хэсэгтээ гэрийн багшийн алба хашиж байв.

Руссо 20 настайдаа Парижад ирж “Нэвтэрхий толь” хэвлэх ажилдаа тохиолдлоор санал болгосон Дидро болон Д’Алембер нартай учирчээ. Гэвч удалгүй үзэл бодлын өөрчилдөөнөөс болоод нэвтэрхий толь бүтээгчдээс холджээ. Тэд боловсролтой борчуулд очрах доромжлолыг бүрэн амссан, доодос гаралтай, харьцангуй эрс сэтгэдэг Руссог бодвол зарчмын асуудалд харьцангуй аядуу байр суурь баримталж байснаас тэдний зам замшид нийлсэнгүй.

Энэ үед Руссо уран зохиол судалж эхэлжээ. “Бодрол: Шинжлэх ухаан болон ирлэгийн сэргэн мандалт зан байдлыг сайжруулсан уу?” гэдэг нэртэй Руссогийн шастир соёл бүрийн уралдаант шалгаруулалтанд тэргүүн шагнал хүртсэн тул Дижоны ШУА-ын шийдвэрээр 1750 онд хэвлэгдсэн нь зохиогчийг ихэд алдаршуулжээ. Дараа нь 1754 онд “Хүмүүсийн хоорондох тэгш бус байдлын шалтгааны тухай”, 1764 онд “Шинэ Элоиза”, “Нийгмийн хэлэлцээрийн тухай”, “Эмиль буюу хүмүүжлийн тухай” шастирууд нь хэвлэгджээ.

Европ дахинаар түүний нэр өргөн тархаж, шинэ бүтээлийг нь хүлээх болжээ. Гэтэл удалгүй аз завшаан орвонгоороо эргэж, 1765 онд Парижийн парламентийн шийдвэрээр католик сүмийг муучилсан үзэл баримталсан ёс суртахуунгүй ном гэж “Эмиль”-ийг нь орон даяар шатаалгажээ. Вангийн засгийн зүгээс Руссог мөрдөж мөшгөн, хараан зүхэх айдал гаргасан ба баривчлагдаж Бастилд хоригдохоос аврагдахын тулд Женевт оргон гарч, жилийн дараа Юмын урилгаар Англид гарсан байна.

Гэтэл удалгүй Юмтай үзэл санаагаар зөрөлдөн муудалцаж, Женевт буцаж ирсэн байна. Энд сүүлчийн ном болох алдарт “Наминчлал”-аа бичсэн байна. Руссог хайрлаж, мөнөө нь сөгдөн мөргөж байсан хүмүүс түүнийг мартсан байхад үзэл санааг нь сэргүүцэгчид мартаагүй байснаас ганцаардал, гуйланчлалд тэр насан өөд болжээ. Францын монархийг түлхэн унагаасны дараа якобинчууд түүний шарилыг Пантеонд очирчээ. Гэтэл бүх ухамсарт амьдралынхаа туршид мэтгэлцэн байсан Вольтерийн царилтай хамт түүний шарилыг сар ч болдолгүй Пантеоноос гаргасан байна. Харин зөвхөн Бүгд Найрамдах Улсын жилүүдэд буцаж тавигдсан ба францын агуу хүмүүсийн шарилын дунд эдүгээ ч нойрсож буй юм.

Руссо эдийн засаг, уран зохиол, философи, гоо зүйн олон бүтээл туурвиснаас урван бүтээл соёл судлалд онцгой ач холбогдолтой юм. Энэ нь Дижоны шинжлэх ухааны

академийн шагнал хүртсэн дээрх бүтээл, “Үзвэрийн тухай Д’ Аламберт бичсэн захидал” “Хэлний үүслийн тухай туршлага”, тэрчлэн “Аялгуу болон хөгжмийн тухай” зэрэг болно. Хүн төрөлхтний дэвших хөдөлгөөний бүх зөрчилт байдлыг сайн харж, өрнөд европын иргэншлүүдийг шүүмжлээд эдгээр бүтээлдээ Ж-Ж.Руссо соёл судлалын хандлагыг хэрэглэх үлгэр жишээг чухам л харуулжээ. Онолын соёл судлалд эдгээр бүтээлийн ач холбогдлыг үнэлэхэд амаргүй. Харин Кант, Гегель, Шиллер, ах дүү Шлегелүүд, Ницше Шпенглер, Ортега-и-Гассет, Хейзинга болон европын соёлын хямралыг авч үзэхэд жинтэй хувь нэмэр оруулсан философи сэтгэлгээний эдгээр гарамгай төлөөлөгчид түүний бүтээлд тулгуурласан байдгийг хэлэхэд хангалттай биз.

Руссо өрнөд европын иргэншлийг шүүмжилж, ард түмнүүдийн эцгийн эрхэт ёсны хөгжлийн шатанд байдаг зан байдлын энгийн бөгөөд цэвэр ариун байдлыг “Соёлтой гэгдэх үндэстний доройтол болон ёс суртахууны завхайралд сөргүүлэн тавьсан байна. Ингэснээр “Туршлага” гэдэг бүтээлдээ байгальтай зохиролд амьдрах, иргэншилд хортой нөлөө үзүүлдэггүй “байгалийн хүн”-ийг суурь болгон гаргаж ирсэн Монтень руу Руссо гэдрэг явсан юм. Руссо “Одоо ховор нандин зүйл, нарийн таашаалыг орхиод урла тодорхой дүрмэнд таалагдан бидний зан авирт олиггүй, хуурмаг нэг төрлийн байдал ноёрхож, бүх ухаантнууд нэг загвараар цутгагдсан бололтой. Эелдэг зан эцэс төгсгөлгүй шаардлага тавьж, зүй ёс зарлигдаж, хүмүүс өөрсдийн оюун ухаанаар бус, заншлыг байнг мөрдөж, яг байгаагаараа л байхыг зүрхлэхгүй юм. Мөнхийн энэ албадлагаар нийгэм гэх нэрлэгдэх сүргийг бүрдүүлсэн хүмүүс нэгэн адил нөхцөлтэйн улмаас хэрэв тэднийг хүчтэй доргиохгүй л бол адилхан л алхам хийж байна. Тийм учраас хэнтэй харьцаад байгаага хэзээ ч мэдэхгүй нь, бие биенийгээ мэдэхийн тулд том үйл явдлыг хүлээх хэрэгтэй болж Ямар гажиг согог энэ итгэлгүй байдлыг дагалдуулав! Чин үнэнч найрамдал ч, жинхэн хүндлэл ч, бүрэн итгэл ч алга. Эелдэг зангийн нэг төрлийн итгэл хөсөрдүүлсэн ба халхавч, магтагдсан хүндэтгэлийн цаана хардалт сэрдэлт, айдас болгоомжлол, үл итгэ байдал, далд санаа, үзэн ядалт, урвалт нуугдаж байна” /2. 46/ гэж бичжээ.

Руссо юмст нүүрлэсэн гунигт ийм байдлын шалтгааныг юуны түрүүнд шинжлэ ухааны хөгжлөөс олж харжээ. Түүнийхээр шинжлэх ухааны хөгжил ухаан санаан хамгийн сөрөг нөлөөл үзүүлэх аж. Түүний үзэж байгаагаар Египет болон Грекий иргэншлийн мөхөл, Ром болон Константинополийн уналтын шалтгаан нь чухам шинжлэ ухааны завхруулагч нөлөө байв. Руссо өөрийнхөө санааг илэрхийлэхдээ нэг бус удаа нэ төрд нь дулдуйдаж байсан Сократын бодролоос өөрийн байр суурийг зөвтгөх нотолгоо олж байсан байна. Руссо Бүгд Найрамдах Улсын үеийн эртний ромчуудын бүтээлд тухайлбал Катоны бүтээлд хандсан байдаг. Катон иргэдийн сайн үйл багассан шалтгааны Грекийн эрдэм мэдлэгтэй холбон үзэж, түүнийг илчилсэн байжээ. Руссо: “Ард түмээн! Энэ нь хүүхдийнхээ гараас аюулт зэвсгийг булааж авч байгаа юм шиг, байгаль та бүхний шинжлэх ухаанаас хамгаалахыг хүссэн болохыг ганц удаа цаашдаа эгнэгт мэдэгтүн. Та бүхнээс шинжлэх ухааны нуусан бүх нууц бол хорлол, та нарыг байгаль түүнээс хамгаалсан, судалгааны хүндрэлийг түүний бага бус буянт үйл бүрдүүлдэг. Хүмүүс эвдэр байна. Гэвч хэрэв эрдэмтэд ... аз жаргалгүй байдлыг төрүүлдэг байсан бол хүмүүс бүр му байх байсан” /3. 52/ гэжээ.

Руссо библийн зөнч Экклезиастын сэтгэлгээг мөшгөн үзээд их мэдэхүй юу сургадаггүй, мэдлэгийг үржүүлдэг хүн уй гашууг үржүүлдэг. Түүгээр барахгүй шинжлэ ухаан дахь үнэнээр хүрэх ашигаас зуу дахин илүү төөрөгдлийн үнээр түүнд хүрдэг. Тийм учраас “эрдэнэс, завхайрал, боолчлол зэрэг нь биднийг мөнхийн цэц мэргэн аваачсан а

жаргалтай харанхуйгаас гарах үргэлж бидний бардам эрмэлзлэлийн өр төлөөс, лай ланчиг болж байсан юм” /4. 53/.

Руссо урлагийг нийгмийн ёс суртахуунд хамгийн сөрөг нөлөөтэй гэж үзээд түүнд таагүй хандсан байна. Тэрээр “Д’Аламберт бичсэн захидал”-даа: “Францын инээдмийн жүжгийн нэлээд төгс жишээг аваад үзье. Гэвч миний бүхнээс илүү авьяасыг нь магтдаг Мольерийн театр гэхэд л зориуд гажиг болон тэнэг зан байдалд сургах зорилт тавьдаг номноос илүү аюултай, тийм зан байдлыг буй болгох бүхэл бүтэн сургууль юм. Сайн үйл, эгэл сэтгэлийг тохуурхаж, заль худал хуурмагт зовниход түүний гол анхаарал чиглэх бөгөөд энд шударга хүмүүс зөвхөн ярьж, гаж уруутан, завхайчууд амжуулж, бүр гялалзсан амжилтанд хүрнэ... Энэ зохиолчийн хошин шогийг харцгаа л даа. Түүний хошин шогийн хөдөлгүүр нь гаж явдал, завхайрал, харин судлагдахуун нь төрөлхийн гологдол дутагдал гэдгийг, зальхай нэг нь энгийн бусдыг цаазалж, тэнэгүүд хар санаатны золиос болдгийг та үргэлж илрүүлнэ” /5. 91/ гэжээ.

Нийгмийн зан байдлыг завхруулах нөлөөний үүднээс үзвэл эмгэнэлт зохиол аюул багатай, гэвч түүнд Руссо итгэл үнэмшилгүй байжээ. Сайн үйлс буяны үлгэр жишээ болж чадах баатрууд эмгэнэлийн хэрэгслээр тэр болгон сайшаагддаггүй тухай баримт Руссо сэтгэглэл төрүүлсэн юм. Энэ жанрын хуулиар нийтээр зөвшөөрөгдсөн ёс суртахууны хэм хэмжээний хүрээнээс баатруудаа үргэлж гаргадаг, тэгэхлээр тэдгээр нь зан суртахууны императивуудтай нийцэж амьдрахыг эрмэлзэгчдэд үлгэр жишээ болж чадахгүй гэж Руссо үзжээ.

Бас драмд элбэг байдаг хэтрүүлэгтэй мэдрэмж, санаанаас зохиосон зөрчилдөөн, чамин дохио зангаанууд амьдралаас маш хол бөгөөд ердийн амьдралтай, дэндсэн шунал тачаалгүй, ялангуяа “гуравдугаар язгуураас” гаралтай хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж чадахгүй. Театрын тайзан дээрх баатарыг шүтэхийг буруушааж, жүжигт үзэгчдийн гүүхэд тэсэн үлдэхүйц үнэнд нийцтэйгээр амьдралыг дүрслэхийг шаардаж, иргэдийн ухаан бодол, сэтгэл санаанд томоохон нөлөөллийг үзүүлдэг институт болох театрын гол зорилт нь ердийн зүйлийг шилдэг үлгэр жишээ болгон үзүүлэх явдал байх ёстой гэж Руссо үзээд хүний амьдралын орон гэрт холбогдох талыг хэт өргөмжилсөн юм.

Руссо урлаг ямагт тансаг сайхны дагуул байсан ба энэ нягт холбооны улмаар өнөөгийн хүчирхэг ертөнцийн оюуны хэрэгцээг юуны түрүүнд хангахыг ямагт эрмэлзсэн байдлыг анзаарч театр төдийгүй, урлагийн бусад төрлүүдийн сайн сайхан болоход өргэлзэх болсон байна. “Тансаг сайхан нь шинжлэх ухаан, урлагийг дагуулахгүй байх нь ховор байдаг, шинжлэх ухаан болон урлаг нь хэзээ ч түүнийг тойрч чаддаггүй” /6. 55/ гэж Руссо бичжээ.

Баячуудыг аргадах явдлыг өөрийн зорилго болгосон урлаг хэрэггүй төдийгүй, түүний үзсэнээр оршин байх эрхгүй. Учир нь захиалагчийн төгс бус таашаалд уран бүтээлчийн таашаалыг зохицуулсаны улмаас гоо сайхны үнэлэмж түүнд байхгүй болдог.

Тансаг сайхныг завхруулагч нөлөөний тухай үзэл санаа Руссогийн бүх бүтээлд нэвт шингэжээ. Руссо тусгаар бодгаль төдийгүй, хүн төрөлхтнийг бүхэлд нь бартаа төвөгтэй замд нь оруулахаар отоож байдаг, бүх золгүй байдлын чухамхүү эцсийн шалтгааныг энд олж харжээ. Тансаг сайхныг эрмэлзсэн хүн өөртөө хуурамч зорилго тавьдаг. Учир нь чамин дарс, тансаг идээ, тавлаг тохитой байдлаар, цэнгэх нь, түүний үзэж байгаагаар, хүний аз жаргалыг олж авах гол бус, зүгээр л нэг урьдач нөхцөл юм.

Руссо тансаг сайхан болон баялгийн ойлголтыг салгаж ойлгосон. Хүн амын аравны ес нь гуйланчлалд амь улжиж, зөвхөн аравны нэг нь тансаг сайханд умбаж буй орон түүнийхээр цэцэглэн хөгжиж буй бус. Тэрээр бичихдээ: “Манай философи тансаг сайхан

төр амжилтыг авчирдаг гэж зуун зууны туршлагыг сөрж баталдаг хачин өгөөмөр болохыг би мэднэ. Гэхдээ тансаг сайхны эсрэг хуулиудын зайлшгүйн тухай умартаад төр бат бэх байхад сайн зан байдал нөлөөлдөг, сайн зан байдалтай тансаг сайхан нийцэхгүй гэдэг үнэнийг философи үгүйсгэж зүрхлэнэ гэж үү. Хэрэв тансаг сайхан нь баялгийн үнэн шинж тэмдэг байж, тэр ч байтугай түүнийг зарим утгаар өсгөн үржүүлэхэд нөлөөлөхийг хүлээн зөвшөөрвөл өнөөг хүртэл байсаар байгаа энэ парадоксоос ямар дүгнэлт хийж болох вэ” /7. 55/ гэжээ.

Эндээс нийгмийн баялагийг өсгөх нь тусгаар бодгалийн эзэмших баялагийг өсгөх явдал биш гэсэн дүгнэлт гарч байна. Руссо тухайн үеийнхээ нийгэмд тогтсон ёс суртахуун, уур амьсгалыг хүлээн аваагүй. Хялбар олз олох, түргэн бөгөөд шудрага бусаар баяжих ухаан бодол түүнд харь ажээ. Руссо мөнгийг шүтээд өөрийнхөө өмнө болон өөрийн хүрээллийнхнийхээ өмнө хүлээсэн өөрийн үүргээ ойлгох хүртэл дээшлэх чадваргүй хүнд жигшингүйгээр ханддаг байжээ. “Эртний улс төрийн бодлоготнууд зан байдал болон сайн үйлийн тухай шударгаар ярьдаг байсан. Манайхан худалдаа болон мөнгөний тухай л ярих юм. Нэг нь танд тухайн оронд хүн ямар үнэтэйг хэлнэ... нөгөө нь тэр тооцоонд баримжаалж хүн үнэгүй байдаг тийм улс орныг олно, харин аль алинд нь хүн үнэгүй үгүйгээс үнэгүй байна. Тэд хүмүүсийг сүрэг мал шиг үнэлж байна. Тэдний үзлээр хүн бүр төрийн хувьд хэрэглэгч байх илэрхий үнэлэмжтэй юм” /8. 55/ гэж Руссо тэмдэглэжээ.

Тансаг сайханд эрмэлзэж, ашиг хонжоо олж баяжих сэтгэлд автагдсан төр өөрийн дайсагнагч хөрштэй мөргөлдөөнд ороход ялагдалд орж сүйрдэг, яагаад гэвэл зарчмын хувьд бие болон оюунаа төгөлдөржүүлж, өөрийн амьдралын зарчмыг олж харсан хүний эсрэг зогсох чадваргүй гэдэг дүгнэлтэд Францын сэтгэгч хүрчээ. Түүний жишээ нь Ромын эзэнт гүрэн байлаа.

Тухайн үеийнхээ нийгмийн байдалд хандаж Руссо зөвхөн оюуны төдийгүй, эдийн засгийн үндсийг нь шүүмжилжээ. Түүнийхээр бүхий л дутагдлын гол шалтгаан нь нийгмийн тэгш бус байдал ба түүний үндсэнд байгаа хувийн өмч юм. Тэрээр: “эдлэн газрыг анх хашсан хүн энэ минийх гэж хэлээд үүнийгээ итгүүлэхийн тулд үнэхээр гэнэн цайлган хүмүүсийг олж, иргэний нийгмийг жинхэнэ үндэслэгч болсон юм. Хог ургамал зулгаан, гуу жалгыг булж яваа өөртэйгөө ав адилхан хүнд энэ мэхлэгчийг сонсохоос сэргийлэгтүн, хэрэв бүтээгдэхүүн бүхэнд хамаарагдаж, харин газар хэнд ч хамаарагдахгүй гэдгийг мартаж юм бол та нар үхнэ гэж хашгирсансан бол тэр хүн хүний төрлийг хичнээн гэмт хэрэг, дайн, аллага, хичнээн золгүй явдал болон айдас хүйдсээс ангижруулах байсансан бол...” /9. 68/ гэж бичжээ. Бүхний төлөө бус, цөөн хүн орлого олохын төлөө үйлчлэх эдийн засаг Руссогийн үзлээр дэмий хэрэггүй зүйл. Учир нь тэгш бус байдлыг төрүүлж, ядуучууд баячуудыг үзэн ядах үр дагвар гарч, нийгмийг дотроос нь хагалдаг байна.

Ийм маягаар Руссо эдийн засгаас урлаг хүртэл нийгмийн амьдралын бүх хүрээнд болж байгаа үйл явдлыг шүүмжлэлтэйгээр авч ухварлаад өрнөдийн иргэншлийн нийгмийн нэгэн анатомыг гаргаж тавьжээ. Тэрээр үр дүнд нь бүр саяхан эцгийн эрхэт ёсны амьдралаар амьдарч байсан олон хүмүүс иргэншлийн баялагт хамаарах төдийгүй, ян бүрийн газар оронд ядуурал гуйланчлал болон баян тансаг байдал ялгаран буй болж өөрийн хөдөлмөрийн үр дүн хийгээд өөрөөсөө хүн хүнийсэх явдал өсдөг нийгмийн дэвшлийн зөрчилт байдлыг харуулсан юм.

Соёл судлаач болохын хувьд Руссогийн утга холбогдол үүнд орших юм. Тэрээр шинжлэх ухаан, техникийн рациональ чанар хүн төрлөхтний хөгжилд аюултай болох тухай анх удаа сэрэмжлүүлэгчдийн нэг юм.

Руссогийн зарим эрэгцүүлэл гэнэн боловч зарим нь хангалттай үндэслэлтэй байдаг. Зарим талаар Руссо өөртэйгөө зөрчилдөнө. Жишээ нь арай эрт үед няцааж байсныгаа хожим нь өмгөөлж байх жишээтэй. Гэхдээ Руссогийн үзэл бодлын зөрчилт байдал нь түүний амьдарч, бүтээж байсан цаг үеийн зөрчилт байдлын үр дагавар юм. Руссо өөрийн шилдэг бүтээлүүддээ тухайн үеийнхээ шинжлэх ухааны гаргаж тавьсан бололцооны хязгаараас хол гарч, ирээдүйг урьдчилан харагчийн ер бусын чадварыг илтгэн харуулж байлаа.

2. Маркиз Виктор Рикети де Мирабо

Онолын соёл судлалын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан соён гэгээрлийн өөр нэгэн сэтгэгч бол Маркиз Виктор Рикети де Мирабо /1715-1789/ юм. Түүний нэр соёл судлалын төдийгүй нийгэм-философийн утга зохиолд бага дурсагдах боловч, өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй олон санааг тэрээр томъёолсон юм. Ялангуяа “иргэншил” гэдэг үгийг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан нь түүнд хамаарагдана. Мирабо олон бүтээл бичсэн боловч хэвлэгдсэнийхээ дараа ихээхэн шуугиан тарьсан “Хүмүүсийн найз (нөхөр) буюу хүн амын тухай шастир” гэдэг түүний ном соёл судлаачдын анхаарлыг онцгой татсан юм.

Өөрийг нь алдаршуулсан эл бүтээлдээ Мирабо анх “civilization” гэдэг үг хэрэглэжээ. Тэрээр удиртгал хэсэгтээ “шашинд зүтгэн үйлчлэгчид сайн зохион байгуулсан нийгэмд тэргүүлэх байр суурийг зүй ёсоор эзэлдэг. Шашин бол хүн төрлөхтний хамгийн шилдэг бөгөөд нэн ашигтай хазаар гэдэг нь маргаангүй, энэ бол иргэншлийн гол пүрш” гэж бичжээ. Иргэншлийн ололттой давуу талын тухай, бүдүүлгийн харанхуйд байгаа орнуудаас гэгээрсэн орнуудын ялгааны тухай Мирабогийн эрэгцүүлэн бичсэн бусад бүтээлүүдэд ч энэ үг (иргэншил) нэг бус удаа тааралдаж байдаг. 1756 онд “ард түмний найз” хэвлэгдсэн үеэс “иргэншил” гэдэг үг франц төдийгүй, европын бусад хэлнүүд дээр биеэ даасан утга тээж ирсэн гэж үзэх үндэстэй.

Мирабо энэ үгийг хожуу хэвлүүлсэн бүтээлүүддээ, тухайлбал “Татварын онол” гэдэг номондоо ч өргөн ашигласан ба “Эмэгтэй хүний найз буюу иргэншлийн тухай шастир” гэдэг дуусгаагүй өгүүлэлдээ ч бичжээ. “Бүх талаараа хуурамч эрэл хайгуулаас болж бид иргэншил гэдэгт юуг ойлгодгийн хувьд бидний үзэл бодол хичнээн хуурамч байдагт... би гайхаж байна. Хэрэв олонхоос иргэншил та бүхний үзэж байгаагаар юунд орших вэ? Гэх юм бол иргэншил бол зан авир байдлыг зөөлрүүлэх, эелдэг, хүндэтгэлтэй байдал, ёс зүйн дүрмийг сахихын тулд болон энэ дүрэм нийгмээр амьдрах хуулийн үүрэг гүйцэтгэхийн тулд дэлгэрүүлсэн мэдлэг болно гэж хэлэх байсан. Бүгд л нүүр царайгаа бус буян хишгийн багийг харуулж байна шүү дээ. Хэрэв иргэншил буян хишгийн үндэс болон хэлбэрийг нийгэмд өгөхгүй бол иргэншил нийгмийн төлөө юуг ч бүтээхгүй” /10. 13/ гэж сүүлчийнхээ бүтээлдээ дурджээ.

Мирабогийн санаагаар бол иргэншил харгис ширүүн, зэрлэг зан авирын илрэлийг гээж, хүмүүнлэг үндсэн дээр суурилсан нийгмийн тогтолцоо бий болоход үүсдэг байна. Нийгмийн тогтолцоо иргэншлийн шатанд шилжих шилжилтийг бас Мирабо шинжлэх ухаан болон урлагийн өндөр түвшин, аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн хөгжил, худалдаа болон мөнгөний эргэлттэй цэцэглэлттэй холбосон байна. Мирабо иргэншлийн дээд зэрэгт хүрсэн улс орны жишээгээр ХҮШ зууны 4 дүгээр хагасын францыг авч үзсэн ба түүнтэй харьцуулахад бусад орны хөгжил ихээхэн доод шатанд оршиж байсан гэж үзжээ. Энэ утгаар тэр Руссогоос тэс ондоо хүн байв.

3. Йоганн Готфрид Гердер

Соёл судлалын үзэл санааны хөгжилд чухал нөлөө үзүүлсэн Европын соёл гэгээрүүлэлтийн үеийн бас нэг том төлөөлөгч бол Йоганн Готфрид Гердер (1744-1803) юм.

Гердер түүхэн үйл явцын жинхэнэ тайлбарлалыг хэлж, түүхийн философийг үндэслэгч гэж европын нийгэм-сэтгэлгээний түүхэнд оржээ. Бас Гумбольдт, Штейнталь, Потенбня нар хожим нь “хэлний философи”-ийг боловсруулахдаа хэлний тухай жинхэнэ түүхэн онолыг бүтээгчдийн нэг гэж түүнийг үзэж, үндсэн баримтлалуудыг нь ашигласан гэдэг.

Олон судлаачид чухам л Гердер соёлын асуудлыг онолын мэдлэгийн асуудал болгон томъёолсон гэж нотлоод түүнийг орчин үеийн соёл судлалыг үндэслэгч эцэг гэж үзэж байна. Үүнийг зарчмын хувьд зөвшөөрч болно, яагаад гэвэл үнэхээр Гердер соёлын дэвшлийн тодорхойлолтыг өгч, түүний агуулгыг нээсэн гэгддэг билээ. Гердер соёл судлалын хандлага бусдаас илүү жинтэй үр дүнг өгдөг гэж үзэж, түүний онцгой эстетик чанарын тухай үзэл санааг бас гаргажээ. Гердер “хүмүүнлэг оюун санаа хийгээд хүн төрөлхтний соёлыг өргөн дэлгэрүүлэх”-д гол нь орших хүний түүхийн зорилгын тухай сэдвийг дэвшүүлж үндэслэсэн юм.

И.Г.Гердер Дорнод Пруссийн нэгэн жижиг хотод амьдрах багшийн гэр бүлд төржээ. 16 настайдаа сургуулиа дүүргэж, жилийн дараа оросын нэгэн офицерын дэмжлэгээр Кенигсбергийн их сургуулийн анагаах ухааны салбарт элссэн ч теологийн факультетэд шилжин суралцаад 1764 онд түүнийг дүүргэсэн байна. Их сургуульд Гердерийн шүтээн нь Кант болон сэтгэлгээний онцлогоор Кантаас тэс өөр Йоганн Георг Гаман нар байв. Гаман бол германы шинжлэх ухааны хүрээлэлд нэрд гарсан, грек, ромын утга зохиолын талаар гаргууд мэдлэгтэн байсан төдийгүй, теологийн асуудлаар гүнзгий сонирхон оролдсон шашны төлөөлөгч байв. Амьдралынхаа замыг сонгоход нь Гердерт эдгээр хүмүүсийн нөлөө нэн их байжээ.

Их сургууль төгсөөд Гердер Рига хотод сүмийн сургуулийн ректорын туслхаар уригдан ажиллажээ. Энэ нь ядмаг гэр бүлээс гаралтай түүнд язгууртны шатаар өгсөм таатай боломж байв. Энэ ажил түүнд аятайгаар нөлөөлж, түүнийг Петербургийн их сургуульд багшаар урьсан байна. Гэвч тэр түүнээс татгалзжээ. Удалгүй үнэн алдартны хуучинсаг үзлээр хөглөгдсөн, пантейзмын үзэл санааг сонирхсон Гердерт нэн таагүй харьцдаг санваартан багш нарын дарамтанд орсноор Ригаг орхихоос аргагүйд хүрч чөлөөт сэтгэлгээний европын төв болох Парист иржээ. Энд бүр Ригад байхдаа олонтой сонсож мэдсэн үзэл санаа бүхий Дидро болон Д'Аламбер зэрэг нэвтэрхий тол бүтээгчидтэй ойртжээ.

Гэвч Парист тун удсангүй жил ч бололгүй германдаа эргэн ирж нэрд гарсан нэгэн герман аристократын албанд оржээ. Гэтэл хун тайжийн болон түүний үе залгамжлагчийн хүмүүжүүлэгчийн ажил Гердерийн сонирхолыг татаж, яг энэ үед Брюкебург дэх нэгэн албаны зөвлөгчийн ажлыг санал болгосонд тэнд оржээ. Энэ хотод 5 жил өнгөрүүлэхдэ оюуны амьдралд хангалттай оржээ. Энэ үед Гердер олон өгүүлэл бичиж Германы нэр хүмүүстэй үр бүтээлтэй холбоо тогтоосон байна.

Тухайлбал, Гётетой хамт “Герман зан чанар болон урлагийн тухай” эмхэтгэлийг хэвлүүлж байв. Гэвч удалгүй 1776 онд Гердер тэр үедээ Германы оюун санааны нийслэл гэгдэж байсан Ваймер дахь тэнхимт сүмийн даргын шинэ албанд уригдан иржээ. Герде

Ваймерийн герцогийн газрын сайд байсан байна. Ваймерт Шиллер, ах, дүү Шлегелүүд болон “Хар салхи ба түрэлт” хөдөлгөөний бусад олон зүтгэлтнүүд амьдарч байлаа. Эдгээр нэрт хүмүүсийг тойрон философи, хэл шинжлэл, уран зохиол судлал, түүхийн салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа авьяаслаг залуучуудын дугуйлангууд буй болжээ. Бурхан тэнгэр ба хүн, байгаль ба түүх, дүрслэх урлаг болон хөгжим хөгжих арга замын тухай эргэцүүлүүд нь нэн өндөр зорилго тавьж, тэдний бүтээл тэр үеийн германы оюун сэтгэлгээний уур амьсгалыг үндсэндээ тодорхойлж байлаа.

Ваймерт Гердер номлогчийн үйл ажиллагааг шинжлэх ухааны эрчимтэй үйлстэй хослуулан өөрийн амьдралын үндсэн хугацааг өнгөрүүлсэн байна. Энэ үедээ Гердер өөрийн гол бүтээл болох “Хүн төрөлхтний түүхийн философийн талаарх үзэл санаа” гэдэг алдарт ном, “Эзэн тэнгэр. Цөөн ярилцлага”, Кантын философийг нягт нямбай авч үзсэн шүүмлэлт шинжилгээ болох “Цэвэр оюун ухааны шүүмжлэлийн мета шүүмжлэл”, “Каллигона” зэрэг олон шастируудыг бичжээ.

Гердер 1804 онд насан өөд болж, түүний шарилыг Ваймерийн тэнхимт сүмийн хананд нутаглуулжээ.

Түүний шарил дээрх хөшөөний хөлд европын философийн сэтгэлгээний хөгжилд чухал хувь нэмэр оруулсан германы соён гэгээрлийн үеийн гарамгай сэтгэгчийн дурсгалд зориулсан цагаан сарнай үргэлж байдаг байна. Түүнийг нас эцэслэсний дараа бүтээлийг нь удаан хугацаанд мартагнажээ. Түүний бүтээлд нь хэн ч бараг, түүгээр барахгүй бүр ойр дотно мэдэх хүмүүс нь ч хандсангүй. Гегель Гердерийг нас барсны дараах хэдхэн жилийн дараа бичсэн өөрийн алдарт “Философийн түүх”-дээ түүний тухай нэг мөр ч оруулсангүй.

Куно Фишерийн “Шинэ философийн түүх” гэдэг нэрд гарсан судалгааг үзвэл Гердерийн үзэл бодолд ердөө дөрвөн тал хуудас зориулсан бол Кантад бүхэл бүтэн боть зориулсан байх юм. Бас энэхүү цөөн хуудас нь муучлах аястай болсноос европын сэтгэгчдийн дунд Гердерийн эзлэх байр суурийн талаар уншигчдад сөрөг сэтгэгдэл төрүүлэхээр болсон байна. Байгаль, нийгмийн тухай Гердерийн зөв зүйтэй тодорхойлолт Гоголийн “Арабески”-д байна. Гердер бас Лев Толстойн ертөнцийг үзэхүйд нөлөөлжээ. “Түүхэн сэтгэлгээний дурсгалууд” номын сан сүүлийн жилүүдэд Гердерийн үндсэн бүтээлийг тодорхой тайлбартай хэвлэсэн байна.

Өнөөдөр гадаад, дотоодын судлаачдаас хэн нь ч Гердер бол цагийн аясаар үзэл санаа нь бүдгэрээгүй жинхэнэ сэтгэгч гэдгийг эргэлзэхгүй байх, иймээс түүнийг соёл судлалын шинжлэх ухааны эцгүүдийн нэг гэж бүрэн үндэстэйгээр тооцон үзэж болно.

Соёлын онолын талаарх Гердерийн үзлүүд нь дээр дурдсан “хүн төрөлхтний түүхийн философийн талаарх үзэл бодлууд”-д илүү бүрэн илэрхийлэгджээ. Чухам энд соёлын гарвалыг нээж, хүний нийгмийн амьдралд түүний гүйцэтгэх үүргийг тайлбарлажээ. “Ард түмний соёл бол түүний ахуйн өнгө, ахуйн мөн чанарын уран яруу боловч мөнх бус, хэврэг эмзэгхэн илрэл юм” /11. 388/ гэж Гердер бичжээ. Энэ тодорхойлолтонд соёлыг хүн төрөлхтний оршихуйн бүх түүхийн турш дахь түүний үйл ажиллагааны үр дүн гэж ойлгож, соёлд хандсан Гердерийн хандлагын гол мөн чанар агуулагддаг.

Гердерт бас соёлын тухайн өөр тодорхойлолт байдаг. Энд тэрээр соёлыг “хүмүүжилтэй” нэн адил авч үзэж, гэрлийн дүрийг санаж, соёлыг гэгээрлийн үр дүн гэж нэрлэсэн байдаг /12. 230/. Гэхдээ эхнийхээ тодорхойлолтонд Гердер илэрхий талтай, хүндэтгэлтэй хандсан байдаг. Яагаад гэвэл түүнийг харгалзан өөрийнхөө онолын байгууламжийг барьсан байна. Гердерийнхээр соёл нь бурхан тэнгэр далдыг нээсэн нь бус, харин хүний практик, байгаль хийгээд нийгмийн ертөнцийг өөрчлөн байгуулах үйл

явцад бүтээгдсэн юм. Соёл, хүний үйл ажиллагаатай холбоотойн тухай үзэл санааг оросын, тухайлбал Э.С.Маркарян, А.Баллер, Л.М.Коган болон соёлын тухай “үйл ажиллагааны” үзэл баримтлалыг бүтээсэн бусад соёл судлаачид хөгжүүлжээ.

Гердер соёлыг хүн бүтээхдээ нэгэн зэрэг өөрийгөө бүтээжээ гэж үзсэн байна. Энд утгаар хүний гарваль нь соёлын гарваль төдийгүй, соёлын гарваль нь хүний гарваль болох нь ээ. Ийнхүү хүний төрлийн хөгжлийн үйл явц, хүний үйл ажиллагааны үйл явц болон хүний түүхэн үйл явц зэрэг нь нягт холбоотой юм. Гердерийн энэ санаа нь цаашид соёлын тухай “персоналист” үзэл баримтлал гэж нэрлэгдэн хөгжсөн байна. Энд соёлын түүхийн субьектийн аспект гэж үзэх магадлал бий.

Гэвч соёлыг юуны түрүүнд хүний үйл ажиллагааны үр дүн гэж Гердер үзээд нэгэн зэрэг үйл явц мөн гэдэгт анхаарлаа хандуулсан байна. Түүний үзсэнээр хүний төрлийн оршин буй мянга мянган жилийн туршид өөрчлөгдөхгүй соёл байдаггүй. Хүн төрөлхтөн түүхэн хөгжлийнхөө замаар ургашлахын хэрээр, “түүхэн үйлийн цар хэмжээ” өсөхийн хэрээр хүний хүчийг хэрэглэх талбар өргөсөж, илүү олон талт хийгээд нарийн болж байгаа соёл ч өөрчлөгддөг. Ийнхүү чанарын байхаасаа илүү тооны утгаар соёлын дэвшлийн тухай ярьж болно.

Гердер “Соёл урагшлан хөдөлж байдаг, гэвч үүнээс төгс төгөлдөр болдоггүй Шинэ байран дээр шинэ чадвар хөгждөг, хуучин байран дээр хөгжсөн өмнөх нь эргэшгүйгээр яваад өгнө. Ромчууд Грекчүүдээс мэргэн цэцэн хийгээд аз жаргалтай байсан уу? Бид Ромчууд, Грекчүүдээс цэцэн хийгээд аз жаргалтай гэж үү?” /13. 426/ гэж бичжээ. Энэ асуултандаа тэрээр эсрэгээр хариулсан, учир нь “хүний уг чанар өөрчлөгдөхгүй үлддэг”, ертөнц бүтээгдсэнээс хойш 10 мянган жилийн дараа хүн тийм л шунал тачаалтайгаа төрсөн, хоёр дугаар ондоо өөрийн бүх тэнэг явдлыг гүйцээн хожмын, төгс бус, ашиггүй цэцэн мэргэнд хүрсэн аж. Бидний амьдрал сөөмхөн хэмжээтэй төөрдөг байшинд тэнүүчилж байна, иймээс энд гарц байсан, байхгүй нь бидэнд ялгаагүй гэжээ. Тэглээ ч гэсэн соёл хөгжин байдаг, гэтэл дэвшлийн зам дээрх хөдөлгөөний шинэ үе шаарх бүрт шинэ соёл буй болох нь байнга гарах өөрчлөлтийг дамжуулах үр дагавар болохгүй гэжээ.

Гердерийнхээр соёл нь өөрийн суурь шинж чанараа хадгалдаг нь аливаа үндэстэн болон ард түмний нэгдмэл /бүхэл бүтэн/ соёл орших тухай ярих боломжийг олгож байна. Гердер бодит байдалд соёл ерөөс оршин байдаггүй, эцсийн дүнд онолын шинжилгээн, хүний нийгмийн соёл гэж нэрлэгдэж болох нарийн төвөгтэй үргэлжлэлийг төрүүлж, өөр хоорондоо нарийн төвөгтэй харилцан үйлчлэлд ордог ялгаатай угсаатны соёл оршин байдаг гэж тэмдэглээд аливаа үндэстэн, ард түмний бүхэл бүтэн соёлд онцгой анхаарсан байна. Бас эдгээр соёлууд ижил тэгш үнэлэмжтэй.

Дээд хэв маягийн соёл гэх Европын соёлын тухай төсөөллийг нь Гердер ог үндэслэлгүй гэж үзжээ. Түүнтэй яг адилаар Европын соёлтой нэг параметрээр ч өрсөлдөх чадваргүй доод соёл болох бусад ард түмний соёлын тухай эргэцүүлэл бас үндэслэлгүй гэжээ. Түүхийн олон тооны жишээнд тулгуурлан Гердер хүн төрөлхтний иргэншил төрсөн Ази тивд сууршин амьдрах ард түмнүүдийн соёлд Европын соёлын эх сурвалжийг хайва зохино гэдгийг тэрээр үзүүлжээ /14. 267-270/.

Чухам Ази тивээс Европын бичиг үсэг, шинжлэх ухаан, дүрслэх урлаг, он тоолол болон одон ертөнцөөр янз бүрийн үйл явдлыг урьдчилан хэлэх зуршил хүрч ирсэн гэх Гердер үзсэн юм. Чухам Азид л хүнд зайлшгүй шаардлагатай хоол тэжээлийн бүтээгдэхүүнийг өгдөг зэрлэг амьтныг анх хүн сургасан байна. Чухам энд газрыг боловсруулах болон үр ашигтай үетэн ургамлыг тариалах анхны туршлагыг

хуримтлуулсан байна. Чухам энд шашны анхны сургаал болон шидэт домог үүссэн. Мөн чухам бусад эх газарт суурьшин амьдрах ард түмнүүд дөнгөж хүрч эхэлсэн төрийн удирдлагын тухай шинжлэх ухаан Азид бүтээгджээ.

“Хаана анх хамгийн том хаант засаг бий болсон бэ? Хаана бүхнээс бат бөх хаант засаг байна” гэж Гердер асуулт тавиад Азид гэж хариулсан байна. Гердерийн төсөөллөөр Ази тивээс бусад эх газруудад соёл тархан дэлгэрсэн. Бусад газрын ард түмнүүд уг соёлыг өөрийн ертөнцийг хүртэхүй, сэтгэл зүйн хэв шинж болон аж төрөх ёсны онцлогт нийцүүлэн шинэчлэн авсан байна. Хэдийвээр нэг үндэстэй үүссэн ч нэг нь нөгөөгөөс эрс ялгагдах үндэсний соёлууд ингэж л үүсчээ.

Гердер үндэсний олон соёл, тухайлбал Хятад, Энэтхэг, Солонгос, Япон, хоёр голын орнуудын соёлыг хэсэгчилсэн алаг цоог, зарим нэг оновчгүй байдалтай ч гэсэн тодорхойлон бичжээ. Тэр үед эртний Египетийн дүрс бичиг, Ассир-Вавилоны тэмдэг бичиг ч арай тайлагдаагүй байсан, Шлиманы нээлт гараагүй байсан, номлогчид дөнгөж л нэвтрэн орж эхэлж байсан Алс дорнодын орнуудын соёлын тухай мэдээ баримт нэн бүдэгхэн байснаар энэ нь тайлбарлагдана. Хятад, Японтой Европын орнууд дипломат харилцаа тогтоож худалдааны тогтмол харилцааг буй болгосон XIX зуунд л Хятад, Японыг европчууд жинхэнээр нээж эхэлсэн байна. Харин монголчуудын талаар Гердер тодорхой дурдаагүй бололтой.

Ийнхүү Гердерийнхээр соёл өөрчлөгдөнө, гэхдээ өөрчлөгдөхдөө соёл өөрийн онцлог шинж чанараа хадгалж, энд өөрийн гол шинж, үүргийг уламжлан залгамжлах чанар гүйцэтгэдэг байна. Гердерийн санаагаар бол “шинэ” соёл “хуучин”-ыг огт үгүйсгэдэггүй. Хуучныг гүйцээн нэмж, түүнийг хөгжүүлэн шинэ соёл хамгийн үнэтэй бүхнийг нь хадгалдаг байна. Гердерийнхээр уламжлан залгамжлах хууль зөвхөн үндэсний соёлын дотор үйлчилдэг төдийгүй, хүн төрөлхтний соёлын ахуй ч түүнд захирагддаг. Соёлын уламжлал нэг үндэстнээс нөгөөд дамжигддаг, ингэж дэлхий нийтийн соёлын аварга том барилгыг янз бүрийн угсаатны хамтын чармайлтаар барьдаг.

Соёлын гарвалыг харуулж, янз бүрийн улс орон, ард түмний соёлын хоорондох харилцаа холбоог нээн илрүүлж соёлын үүслийн шалтгаан зэрэг төвөгтэй асуудлыг Гердер хөнджээ. Түүнийхээр хүн байгалиас өгдөг зүйлээр зөвхөн хангагдахгүй, хүний объектив хэрэгцээ байдаг учраас соёлын ертөнц үүсдэг. Хэрэгцээ гачаал нь түүний үзсэнээр хүний соёлын бүтээлч үйл ажиллагааны үндсэнд орших зүйл, амьдралд соёлыг дуудах, түүний хөгжлийн үйл явцыг нөхцөлдүүлэх эцсийн шалтгаан юм. Үүний зэрэгцээ соёл дэвших замаар хүн төрөлхтөн ямар нэгэн шинэ зүйл буй болгох, аль нэгэн нээлтэнд объектив дэмжлэг үзүүлэх нөхцөл байдал болон тохиолдлыг дэвшүүлэн гаргадаг гэж тэрээр үзжээ. Соёлын үүсэл, хөгжлийг нөхцөлдүүлэх шалтгааныг судалж Гердер соёл төлөвших газарзүйн хүчин зүйлийн гүйцэтгэх үүргийг хөнджээ.

Шашны хэв маяг, төрийн байгууламжийн хэлбэр болон эдийн засгийн харилцааны хэв маяг юуны түүрүүнд тухайн орон хаана оршиж байна, ямар байгаль орчин болон уур амьсгалтай байна гэдгээр тодорхойлогдоно. Ингэснээрээ Гердер “хуулиудын санааг” улс орны газарзүйн байрлалаас гаргаж авч үздэг Монтескьегийн араас оржээ. Гэхдээ Гердер Монтескьегоос цааш явсан байна. Гердер уур амьсгалын өөр өөр бүсэд орших ард түмнүүд эрс ялгаатай соёлтой, байдагт анхаарлаа хандуулжээ. Тэрээр энд абиссууд, египтчүүд, персүүд болон арабчуудын аж төрөх ёс, оюуны дүр төрхийн хоорон дахь ялгааг баталгаа болгожээ. Эндээс тэр зөвхөн улс орны байрлал төдийгүй ямар нэг өөр хүчин зүйл соёлын хэв маягийг нөхцөлдүүлдэг гэсэн дүгнэлт хийсэн байна. Тийм хүчин зүйлийн нэг нь байгалийн хязгаарлал /уул, ус, тэнгис, далай/-аар газар нутаг хуваагддаг

орших аж. Энэ хязгаарлал нь соёл хоорондын тусгаарлалт болно. Гердер далай тэнгис бол ард түмнүүдийг зөвхөн зааглах төдийгүй, бас нэгтгэн нийлүүлэх үүрэгтэй гэж онцлон тэмдэглэжээ. Энд Газрын дундад тэнгисийг жишээ болгож бичихдээ түүнийг “Европт эртний болон дундад зууны соёл хүрэлцэн ирсэн” /15. 32/ гүүр гэж үзжээ.

Соёлын эх сурвалжийг Гердер тайлбарлахдаа тоо төдийгүй чанараар өөр хоорондоо эрс ялгагдах “эрдэмтдийн соёл” болон “ард түмний соёл” гэдэг ойлголтыг оруулжээ. Эрдэмтдийн соёл нь нарийн төвөгтэй бөгөөд зөвхөн гэгээрсэн хүмүүс л түүнийг эзэмшиж чадах бол ард түмний соёл нь энгийн бөгөөд бүхэнд хүртээмжтэй юм. Эрдэмтдийн соёл бол олон нийтийн хүмүүжил болон гэгээрлийн зорилт үүрсэн, тэрчлэн иргэншлийн оршин байх олон зуун жилийн турш хүн төрөлхтний хуримтлуулж, үеэс үед мэдлэг дамжин хадгалагдах үүрэг хүлээсэн онцгой язгуурын нарийн нийлмэл соёл юм.

Эрдэмтдийн соёлд харьцсан хүн анагаах ухаан, математик тооллын нууцыг, хүмүүсийг удирдах аргыг эзэмшинэ. Түүний ачаар чухам л олон зууны өмнө болсон үйл явдлын тухай үнэн төсөөлөл үе үеийн хүмүүсийн ой тойнд хадгалагддаг. Мэдлэгийг хадгалагчдын үүргийг Энэтхэгт брахманууд, Хятадад мондаринууд, Төвдөд лам нар, Европт санваартнууд гүйцэтгэдэг гэжээ. Гердерийн бичсэнчлэн энэ төрлийн хүмүүс хосгүй нарийн нандин соёлын үрийг бүх улс орон, эх газраар цацахын тулд төрж оршин байдаг. Тэдэнгүйгээр соёл жинхнээрээ орших нь зарчмын хувьд боломжгүй.

Ард түмний соёл бол дээд математик, хөгжмийн дуурьсал, эсвэл дүрслэх урлагийн зарчмуудыг мэдэх албагүй тийм олон нийтийн соёл юм. Энэ нь зөв зан төлөв, ашигтай үйлдвэрлэл, шашны үндсэн баримтлал гэхчлэнг эзэмшихэд л оршино. Өөрийн гэр бүл, төрийн сайн сайхны төлөөнөө цуцалтгүй хөдөлмөрлөж, библийн сургаалд нийцүүлэн зан үйлээн зохицуулж амьдарсан хүнийг соёлтой хүн гэж нэрлэх ажээ. Тэрээр Гердер “ард түмэн философи болон шашны онолын төлөөнөө бүтээгдээгүй... Эдгээр нь ард түмэнд ашиг тусаа өгдөггүй” гэдэгт итгэлтэй байжээ. Гердер энэ хоёр соёлыг онол хийгээд практик дээр ойртуулах нь хэрэггүй төдийгүй, дэмий гээд олон нийтийн соёлд шинэ үзэл санаанууд оруулах тухай францын соёл гэгээрүүлэгчдийн оролдлогыг маш шүүмжлэлтэй авч үзэж, хичнээн сайн үйл байсныхаа хэрээр төдийчинээ муу үйл болсон гэжээ.

Гердер “Одоо бид эрдэмтийн хийгээд ард түмний соёлын хүрээг ихээхэн хутгалаа, ард түмний соёлыг эрдэмтдийн соёлын хэмжээнд хүртэл аваачсан нь ашиггүй бөгөөд хортой юм” /16. 311/ гэж бичжээ. Гердер соёлын үүсэл, хөгжилд шашин тодорхойлогч үүрэг гүйцэтгэсэн гэж үзсэн байна. Түүнийхээр шашин нь соёлыг бүрэлдүүлэгч бусад хэсгүүдийг захирах соёлын хамгийн эртний гол элемент юм.

Гердер “Зөвхөн шашин л ард түмэнд шинжлэх ухаан, соёлыг авчирч өгсөн, соёл болон шинжлэх ухаан нь анхандаа зүгээр л шашны онцгой уламжлал байсныг үгүйсгэж болохгүй. Бүх зэрлэг ард түмнүүдийн үлэмжхэн мэдлэг, соёл нь эдүгээ хүртэл шашинтай холбоотой байна. Эдгээр ард түмнүүдийн шашны хэл нь баяр ёслолын, илүү дээд чанартай, ариун ёслолын үеэр энэ хэлээр бүжиг, дуу хууртай ярьцгаадаг. Энэ хэл балар эртний үүдэлтэй, эртний түүхээс үлдсэн цорын ганц зүйл, мэдлэгийн гэгээ сүүмэлзэх хүй нэгдлийн үеийн дурсгал юм. Цаг хугацааг тооцоолох үндэс болох тоо болон өдрийн тоолол нь ямагт ариун мэдлэг байсан, одоо ч ариунаараа үлдсэн, байгаль болон тэнгэрийн тухай мэдлэг... өөртөө аль эртнээс орчлонгийн бүх хэсгийн ид шидийн чанарыг олж авсан Хүний сэтгэлийг зовоосон асуулт болон шийдвэрийн бүх харанхуй ноёрхол, зүүд тайлах нууцын тухай мэдлэг, анагаах ухаан болон урьдчилан хэлэх урлаг, үсэг болон хүн бурхан тэнгэртээ хүлцэн эвлэрэх аргын тухай мэдлэг бүгд мэргэч төлөгчдийн гарт байна” /17 253-254/ гэж бичжээ.

Гэхдээ шашны уг чанарын тухай Гердерийн ойлголт шашны ягшмал номлолоос ялгаатай юм. Тэрээр шашны үүслийг байгалийн шалтгаанаар тайлбарладаг. Хүний ургуулан бодохуй нь харж үзэгдэх бүхнийг амилуулж, үл үзэгдэх юмаар агаар, газар, усыг дүүргэж байдаг гэж тэрээр үзжээ. Шашны заншил бол анимализм болон хүй нэгдлийн сүсэглэлээс онгон шүтэхүй, бөө мөргөл, олон бурхант үзэлд, тэндээс ягшмал номлол, ёс зүй, танин мэдэхүйн онол болон ахуйн тухай сургаалд нэг бүрчлэн боловсруулагдсан монотеизмд хүрсэн зам мөн гэж Гердер үзжээ.

Соёлын тухай Гердерийн үзэл баримтлалд хэлний тухай түүний үзэл сургаал чухал юм. Мэдээлэл дамжуулах хэлэхүйн аргын асуудлаар тэр “Хэлний үүслийн тухай шастир” болон “Хүн төрөлхтний түүхийн философийн үзэл санаа” номондоо ярьжээ. Түүнийхээр хэл нь хүн төрөлхтний соёл үүсэж буй болоход шашнаас дутахгүй чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Аливаа үндэстний соёл цутган орж байдаг хэлбэр гэж хэлийг тэрээр дүрслэн үзүүлжээ. “Аливаа хэл нь ард түмний үзэл санаа, төсөөлөл юүлэгдэж, хадгалагдаж, дамжигдаж байдаг сав юм. Ялангуяа хэрэв ард түмэн өөрийн хэлэндээ хайртай байж өөрийн бүх соёлоо хэлнээсээ гаргаж ирж байвал ...” /18. 297/ гэх мэтчилэнгээр Гердер бичжээ. Түүний үзсэнээр хэл нь бурхан тэнгэрийн нөлөөгөөр үүссэн бус, харин өөр хоорондоо хүмүүс харьцах зайлшгүй шаардлагаар үүсчээ. Байгалийн авиаг хүн дуурайхаас хэл үүссэн гэж үздэг Лейбницийн санааг Гердер үгүйсгэж, сэтгэл ихэд хөдөлснөөр амьдралд анхны авиа буй болоод хүний янз бүрийн шунал тачаалыг дагалдуулсан гэж үзсэн Руссог ч зөвшөөрсөнгүй. Тэрээр үйл үг буй болоход хэл үүссэн, өөрөөр хэлбэл хэлний хөгжлийн логик нь хүний үйл ажиллагааны логиктой нягт холбоотой гэжээ. Үйл үгнээс юмсын тодорхой шинжийг тээсэн анхны нэр үгүүд алгуур үүсэж эхлэн, улмаар тэдгээрийг тойрон тэмдэг нэр, биеийн төлөөний үгс, үйлт нэрс буй болжээ гэсэн байна. Элэнц хэл ид шидийн практик, шашны ёс үйлтэй нягт холбоотой байсан учраас яруу найргийн гэмээр байдалтай байснаа дараа нь хүмүүс үргэлжилсэн үгээр ярьж ерөнхий ойлголтуудыг хэрэглэх болсон, математикч, байгалийн шинжлэлийн төлөөлөгчдийн ярьдаг бэлгэ тэмдгийн хэл нь түүхэн удаан хугацааны үр дүн гэж үзжээ.

Гердерийнхээр хэл бол хүний сэрлийг илэрхийлэх универсаль хэлбэр аж. Хэлний тусламжаар хүний сэтгэлийн янз бүрийн төлөв байдал, сэтгэцийн нарийн зүйлийг илэрхийлж болно. Янз бүрийн ард түмнүүдийн хэлэнд мэдэрч хүртэхүйн янз бүрийн өнгө аясыг дамжуулах ижил болоод эсрэг утгат үгүүд, үйлт нэр болоод нөхцөлт үйл үг байдгийн учир энэ юм. Хэлний баялаг нь нэг л адил үйл буюу харилцааг тусгах төрөл үгсийн баялгаар тодорхойлогдоно. Энэ утгаар онцгой баялаг хэл бол араб хэл юм. Жишээ нь, арсланг тавь, могойг хоёр зуу, илдийг мянган ижил төстэй утга бүхий үгээр илэрхийлдэг байна. Хэл мөхөх нь Гердерийн үзсэнээр соёл алдагдах урьдач нөхцөл болно. Ийм учраас үндэстний хэлийг хадгалах, хөгжүүлэх нь төрийн чухал зорилт гэжээ. Хэл шинжлэлийн суурь үндэслэл гэж үзэхүйц 4 хуулийг Гердер томъёолжээ. Үүнд:

Нэгдүгээрт - Хүн бол хүч нь завсарлагагүй өсдөг, чөлөөтэй сэтгэгч амьтан, ийм учраас хүн яригч бүтээл юм. Энд гүн гүнзгий санаа агуулагдаж байгаа нь харагдаж байна. Амьтны ертөнцөөс хамгийн хүчтэй нь хүн хараахан бус, байгалийн шалгарлын явцад эсэн мэнд үлдэхэд түүнд нуугдмал оюун гэсэн утгаар Гердерийн ойлгосон “ухаалаг байдал” нь нөлөөлжээ гэдгийг тэрээр иц үндэс болгосон байна;

Хоёрдугаарт - “Хүн өөрийн зориулалтаараа сүргийн, нийгмийн бүтээл юм, ийм учраас хэлний хөгжил түүнд жам ёсны, гол, зайлшгүй юм болно”. Зөвхөн бусад хүмүүстэй харьцах болон хамтран ажиллах явцад homo sapiens болсон хүний нийгмийн мөн чанар энэ хуулинд тэмдэглэгджээ;

Гуравдугаарт - “Бүхэлдээ хүний төрөл нэг сүрэг болж үлдсэнгүй, нэг хэлийг хадгалж чадсангүй, ийм учраас янз бүрийн үндэстний хэл үүсэх нь зайлшгүй байжээ”. Хүн бүр давтагдашгүй өөр байдаг шиг хэл бүр яг адил давтагдашгүй ховор юм. Үүний зэрэгцээ янз бүрийн хэлний хооронд ямар нэгэн ерөнхий зүйл байна, учир нь түүгээр нэг л түүхэн субъект болох хүмүүний төрөл ярьж байгаа юм. Хэлнүүд, ард түмнүүд ч тусгаар үг, илэрхийлэл, бүх л бүтэн хэллэгийг зээлдэх замаар харилцан бие биенийгээ баяжуулан харилцаанд ордог гэж Гердер үзсэн. Ашиглагдаж байгаа хэл байнга хөгжиж, хүний мэдрэмж болон санаа бодлын өнгө аясыг улам илүү тусгах чадвартай нарийн боловсронгуй болдог;

Дөрөвдүгээрт - “ Хүний нийгэм үүссэн үеэсээ л... дэвшлийг хангагч бүтэн зүйл байсан гэдэгтээ төстэй бүх хэлний тухай, соёлын бүх гинжин хөгжлийн тухай бас ингэж хэлж болно”.

Соёлын онолд Гердерийн эзлэх байр суурь нь түүнд эдийн засагч, улс төрч, байгаль шинжээчийн үүднээс бус, зөвхөн философичийн байрнаас хандсанаар тодорхойлогдоно.

Ийнхүү европын соён гэгээрлийн үеийн томоохон төлөөлөгчдийн бүтээлд соёлын тухай асуудал илүү онолын чанартай болж ирсэн юм. Өөрөөр хэлбэл байгаль болон нийгмийн хөгжлийн хуультай хараахан давхцахгүй өөрийн өвөрмөц хуулиар хөгждөг, онтологийн бодит байдал гэж соёлыг үзэх болсон байна. Чухам энэ үеэс соёлын дэвшлийн шулуун шугамын бус, тэрчлэн зөвхөн урагш хөдлөх хөдөлгөөн төдийгүй, арагш ухрах явдал гэж үзэх болжээ. Энэ цаг үед нэн хөвсгөр агуулгатай “соёл” хэмээх ойлголт хангалттай тодорхой утга бүхий эрдэм судлалын категори болж хувирсан байна. Мөн энэ үед “соёл”, “иргэншил” хоёрыг ялгах оролдлого хийгдэж эхэлжээ. Соён гэгээрлийн энэ цаг үед соёлын асуудалд хүн, түүний эрх чөлөөний асуудалтай эгнэгт холбогдож, түүх аль нэгэн үйл явдлуудын цуглуулга гэж үзэгдэхээ больж, “хүнийг бүтээхүй”-н үйл явц гэж үзэгдэх болсон юм. Ийнхүү соён гэгээрүүлэгчид соёлын тухай түүхэн харьцуулалтын судалгааны уламжлалыг үндэслэжээ.

Ишлэл авсан бүтээлүүд

1. Ф.Энгельс. Дюрингийн эсрэг. УБ.: Улсын хэвлэлийн газар, 1979.
2. Руссо Ж.-Ж. Рассуждение, способствовало ли возрождение науки и искусств улучшению нравов? // Руссо Ж.-Ж. Избр. Соч: В 3 т. – Т.1. – М., 1961.
3. Мөн тэнд
4. Мөн тэнд
5. Руссо Ж.-Ж. Письмо к Д' Алемберу о зрелищах // Руссо Ж.-Ж. Избр. Соч: В 3 т. – Т.1. – М. 1961.
6. Руссо Ж.-Ж. Рассуждение, способствовало ли возрождение науки и искусств улучшению нравов? // Руссо Ж.-Ж. Избр. Соч: В 3 т. – Т.1. – М., 1961.
7. Мөн тэнд
8. Мөн тэнд
9. Руссо Ж.-Ж. О причинах неравенства между людьми. – СПб., 1907
10. Бенвенист. Основы лингвистики. – М., 1976
11. Гердер Й.Г. Идей к философии истории человечества. – М., 1977.
12. Мөн тэнд
13. Мөн тэнд
14. Мөн тэнд
15. Мөн тэнд
16. Мөн тэнд
17. Мөн тэнд
18. Мөн тэнд